



28

БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/16

Номгон

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянхонгор сумын "2022, 2023 онд хийгдэх ажлын хэмжилтийн гүйцэтгэлийн зураг хийх" ажлыг гүйцэтгэх БХАБХСЗДТГ/202312008 дугаартай гэрээний дагуу хийгдсэн ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Пүрэвжаргал

(Захирагчийн албаны дарга)

Гишүүд:

Т.Оюунгэрэл

(Худалдан авах ажиллагаа хариуцсан

мэргэжилтэн)

Ц.Нармандах

(Эрчим хүчний асуудал хариуцсан ажилтан)

Д.Оюун-Эрдэнэ

(Санхүүгийн албаны дарга)

Нарийн бичгийн дарга:

Ц.Баасанбат

(Газар зохион байгуулалт инженерийн шугам

сүлжээ зам талбай хариуцсан ажилтан)

2. Тендерийн баримт бичигт тулгуурлан, техникийн тодорхойлолт, бараа ажил үйлчилгээ нийлүүлэх гэрээ зэргийг үндэслэн дээрх ажлыг нягтлан шалгаж хүлээлцэхийг ажлын хэсэгт даалгасугай.

3. Ажлын гүйцэтгэл, ажил хүлээлцсэн тайлан, дүгнэлтийг Засаг даргын зөвлөлд 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Пүрэвжаргал)-д үүрэг болгосугай.

6 : 1010827

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч  
(С.Батцэрэн)-д даалгасугай

ДАРГА  Г.ЭНХБАЯР